



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 10 сарын 25 өдөр

Дугаар 518

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дархан-Уул аймаг дахь Мэргэжлийн хяналтын газар (хуучин нэрээр)-ын эзэмшилд байсан 30,800,000.00 (гучин сая найман зуун мянга) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Дархан-Уул аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Дархан-Уул аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Д.Бат-Эрдэнэд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө бүртгэлд тусгах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн "Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай" 63 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл) т үүрэг болгосугай.


ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ





Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн
318 дугаар тогтоолын хавсралт

Дархан-Уул аймаг дахь Мэргэжлийн хяналтын газар (хуучин нэрээр)-ын эзэмшилд байсан
Дархан-Уул аймгийн өмчид бүртгэх автомашины жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон он	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг
			(төгрөг)		
1	Тоёота Хайс маркийн 00-32 ДАУ улсын дугаартай	2021/ 2019	30,800,000.00	9,432,589.21	21,367,410.79
	Нийт дүн		30,800,000.00 (гучин сая найман зуун мянга)	9,432,589.21 (есөн сая дөрвөн зуун гучин хоёр мянга таван зуун наян есөн төгрөг хорин нэгэн мөнгө)	21,367,410.79 (хорин нэгэн сая гурван зуун жаран долоон мянга дөрвөн зуун арван төгрөг далан есөн мөнгө)